


“Арматур бэхжүүлэх барилгын ажил ба арматурын зангидах ажил”

Хөдөлмөр хамгаалал эрүүл ахуйн чухал цэгүүд

Үйлдвэрийн ажлууд

(1) Үйлдвэр дотор олон аюул байдаг (боловсруулах үйлдвэр)!

- Боловсруулах ажиллагааны үед олон осол гардаг.
- Машины ажиллагаанаас шалтгаалсан хүнд гэмтэл гэдгийг өөртөө сануулаарай!
- Өөрийгөө хамгаалаарай, ингэснээр ажил эхлэх үзлэгийг осолгүй хийнэ.



Төмөр утсыг сайтар шалга.

Татлагын утасны үзлэг

* Утас тасарна! Утасны нөхцөл ба унжих өнцгийг шалга!



1. Утасны 10% юмуу түүнээс их хувь нь нэг удаагийн мушгиралтаар эвдэрдэг
2. Голчтой утас 7%-иас илүү буурдаг
3. Нугарсан утас
4. Томоохон хэлбэр алдалт муу зэврэлттэй
5. Гэмтсэн нүдтэй утас
6. Гав юмуу хавчаараар хэлбэрээ алдсан юмуу хагарсан утас
7. Өөрийн үндсэн уртаас 5%-иас илүү сунасан гинжүүд

(2) Цэвэрлэгээ тогтмол хийж, цэвэр цэмцгэр байдлыг хангаснаар ажлын бүтээмжийг нэмэгдүүлж, ослыг бууруулна!

Үр ашигтай ажиллахын тулд гэмтэл бэртэлгүй ажлын байрыг бий болго!

Ангилах, цэвэр цэмцгэр, цэвэрлэгээ ба цэвэр байдлын үйл ажиллагаа

Ангилах

Хэрэгтэй хэрэггүй зүйлийг ялгаж, шаардлагагүй яаралтай бус зүйлүүдийг хаях.

Цэвэр цэмцгэр

Хэрэгтэй зүйлээ зориулалтын газар хадгалж, ашиглахад бэлэн байлга.


Цэвэр байдал

Ангилах, цэвэр цэмцгэр, цэвэрлэгээ, цэвэр байдлыг хадгалсаар бай.

Цэвэрлэгээ

Бохир, хог хаягдлыг цэвэрлэж чөлөөл, асуудлыг ол.

(3) Тохиолдол 1: Машины ажлын осол



Тохиолдлын нөхцөл


Жижиг голчтой хүчитгэсэн ган арматурыг мөрлөх зуураа хохирогч шалан дээр хэвтэж байсан хүчитгэсэн ган арматур дээр гишгэхэд арматур нь өнхөрч ажилчин мөрөнд дээрээ арматур барьсаар унасан.

Хүчитгэсэн ган арматурыг боодлын олсоор уяагүй учраас түүхий эд (шулуун арматур) хялбархан өнхөрнө.

Дагаж мөрдөх ёстой зүйлүүд

1. Түүхий эдийг (шулуун арматур) шалан дээр тавихдаа тэдгээрийг өнхрөхөөс сэргийлэхийн тулд боосон эсэхээ шалга.
2. Гарах хаалганд ямар нэгэн материал бүү тавь.

(4) Тохиолдол 2: Ажил хийх үеийн осол



Тохиолдлын нөхцөл

Хохирогч шалан дээр унасан тайрдсыг тонгойж аваад буцаж өндийхдөө ажлын ширээг цохисон.

Нарийн газраар бөгтийж, авах зүйлээ авахын тулд зохисгүй байрлал авсан. Ажлын ширэг ажилгүйгээр яаран боссон.

Дагаж мөрдөх ёстой зүйлүүд

1. Нарийн газраар бүү яв.
2. Түүнийг авахын тулд соронз юмуу соронзон гар ашиглаж, зохисгүй байрлал бүү ав.
3. Биед хүрэхээс зайлсхийхийн тулд материал ба ажлын ширээний байрлалыг байнга шалга.
4. Тайвнаар ажлаа хий.

(5) Тохиолдол 3: Ажил хийх үеийн осол




Тохиолдлын нөхцөл

Хүчитгэсэн арматурын төмрийг ашиглан гараар нугалах үед арьсан бээлий өнхрүүлд хавчигдаж, хохирогчийн гар гэмтсэн. Тэрээр ажилдаа дадсан, хэт их итгэлтэй ч гартаа анхаарал дутуу хандуулсан. Бээлий сул байсан. Тэрээр хүчитгэсэн арматурын төмрийг өнхрүүлд ойр барьсан.

Дагаж мөрдөх ёстой зүйлүүд

1. Анхаарлаа хандуулж, ажлыг давтан хийхдээ инерцийн төв бүү болоорой.
2. Зохих ёсны хамгаалах хэрэгсэл өмсөж ажилла.
3. Та хавчуулагдлаа гэж бодоход барих эд ангийг хай.

(6) Тохиолдол 4: Ажил хийх үеийн осол**Тохиолдлын нөхцөл**

Боодолтой арматурыг кранаар өргөж барихдаа хохирогч материалыг нэг гараараа барьж нөгөө гараараа алсын удирдлагыг ажиллуулж байгаад материалаар цохиулж алдаа гаргасан.

Алсын удирдлагыг нэг гараараа ажиллуулж, нөгөө гараараа материалыг барьж байсан. Тэрээр материалаа бариад завгүй байсан учраас товчлуурыг шалгалгүй ажиллуулах товчлуурыг дарсан.

Дагаж мөрдөх ёстой зүйлүүд

1. Алсын удирдлагыг аль болох хоёр гараараа ажиллуулж, байрлалыг баталгаажуулахын тулд товчлууруудыг дар.
2. Өөр зүйл хийж байхдаа өөр зүйл бүү хий. Алсын удирдлагын ажиллагаанд төвлөр.
3. Урт зүйлийг хоёр хүн хөдөлгөнө.

(7) Тохiolдол 5: Ажил хийх үеийн осол**Тохiolдлын нөхцөл**

Том голчтой хүчитгэсэн арматурын төмрийг нугалсны дараа хохирогч нугалсан материалыг доошлуулж хүчитгэсэн арматурын хурц ирмэгт гараа зүссэн.

Энэ ажил нь энгийн бөгөөд машинаар ажиллах хэмжээ их байсан учраас түүнийг инерцийн төлөвт орсон. Тэрээр хүчитгэсэн арматурын төмрийн хурц байдлыг мартаж, түүний анхаарлыг сарниулсан. Зуны дунд сард, үйлдвэр доторх температур нь өндөр байсан учраас ханцуйгаа шамласан байв.

Дагаж мөрдөх ёстой зүйлүүд

1. Энгийн бөгөөд өөрийн мэддэг юмаа хийх үедээ анхаарлаа нэмэгдүүлж, инерцид орохоос зайлсхий.
2. Хүчитгэсэн арматурын тасалсан ирмэг нь ир мэт хурц байдаг.
3. Зуны халуун өдрүүдэд ч ханцуйгаа бүү шамла.
4. Гарын арыг болон бугуйн хаалт өмсөх нь маш үр дүнтэй байдгийг санал болгож байна.

(8) Үйлдвэрт гэмтлээс урьдчилан сэргийлэхийн тулд (боловсруулах үйлдвэр) (Хураангуй)

- Татлагын утас ба унжих өнцгийг сайтар шалга!
- Үйлдвэр дотор ч Ангилах, цэвэр цэмцгэр, цэвэрлэгээ ба цэвэр байдлын үйл ажиллагаа шаардлагатай! Энэ үйл ажиллагааг хэрэгжүүл!
- Ажлын гарцыг аюулгүй болгоод, материал дээр бүү алх!
- Бариу газар луу гараа бүү хий!
- Бээлий (ажлын даавуун бээлий) машинд хавчуулагдсан олон тохиолдол байдаг учраас болгоомжтой байгаарай!
- Краныг ажиллуулах үед ажиллагаанд төвлөрч, ачаа савлах тал дээр асуудал байхгүй байрлалд ажиллуул!
- Хүчитгэсэн арматурын ирмэг маш хурц байдаг! Иртэй ажиллахдаа мэдрэмжтэй байгаарай!

Барилгын талбайд ажиллаж байхдаа аюултай газарт ажиллаж байгаагаа мартаж орхидог. Хүмүүс орчиндоо амархан дасдаг. Та аюултай ойр байдаг гэдгээ байнга санаарай.